ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДУА-2024/119/НА-СТА-ТШЗ**

---


Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn



Цахим хуудас: www.audit.mn

Дундговь аймаг

2024 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон, 7-р бай, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208. Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-02-19 № 21

танай ____________ -ны № ____________ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Р.ОТГОНБААТАР ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 07 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.4 дахин өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

**Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2 зорилт, 57 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, сумын Засаг даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 94.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

1020240009

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үзд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Р.МӨНХТОГТОХ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | **197,073,541.57** | **233,440,655.11** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | | **10,542,003.94** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | | 10,542,003.94 |
| 31210 | Төгрөг | | 10,542,003.94 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | | 10,542,003.94 |
| **33** | **АВЛАГА** | **8,556,939.00** | **8,606,253.00** |
| 33500 | Бусад авлага | 8,556,939.00 | 8,606,253.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 12.00 | 49,326.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 8,556,927.00 | 8,556,927.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **58,184,502.57** | **63,504,959.17** |
| 35400 | Хангамжийн материал | 48,134,502.57 | 53,454,959.17 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,151,150.00 | 1,489,650.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 40,804,109.17 | 46,069,109.17 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 3,557,043.40 | 397,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,622,200.00 | 2,622,200.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 2,877,000.00 |
| 35600 | Мал амьтад | 10,050,000.00 | 10,050,000.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | **130,332,100.00** | **150,787,439.00** |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө (ТӨҮГ) | 98,000,000.00 | 118,455,339.00 |
| 36900 | БЗЭ буй эргэлтийн бус хөрөнгө | 32,332,100.00 | 32,332,100.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)** | **1,443,611,831.24** | **1,308,402,465.06** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,443,611,831.24** | **1,308,402,465.06** |
| 39200 | Биет хөрөнгө | 1,432,797,664.71 | 1,287,374,336.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,523,652,877.50 | 1,565,752,875.50 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | (300,140,197.47) | (449,773,283.92) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 185,479,673.00 | 197,329,673.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | (126,097,301.91) | (148,986,756.34) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 211,765,793.50 | 257,565,392.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | (103,341,577.62) | (148,530,343.50) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 97,504,190.01 | 97,504,190.01 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | (61,345,960.62) | (86,402,510.94) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 15,713,191.00 | 16,163,191.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө | (10,393,022.68) | (13,248,091.20) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 10,814,166.53 | 21,028,128.95 |
| 39301 | Програм хангамж | 1,760,000.00 | 6,546,625.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж | (1,585,833.47) | (2,174,496.05) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 10,640,000.00 | 16,656,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)** | **1,640,685,372.81** | **1,541,843,120.17** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)** | **1,258,820.00** | **982,120.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **1,258,820.00** | **982,120.00** |
| 41300 | Өглөг | 1,258,820.00 | 982,120.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 1,258,820.00 | 982,120.00 |
| 413205 | Тээвэр, шатахууны өглөг | 122,120.00 | 122,120.00 |
| 413213 | Бусад зардлын өглөг | 1,136,700.00 | 860,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | **1,639,426,552.81** | **1,540,861,000.17** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,639,426,552.81** | **1,540,861,000.17** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 448,675,224.79 | 448,675,224.79 |
| 511001 | Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан | 448,675,224.79 | 448,675,224.79 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 988,135,986.03 | 889,570,433.39 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 988,135,986.03 | 988,135,986.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (98,565,552.64) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 202,615,341.99 | 202,615,341.99 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)** | **1,640,685,372.81** | **1,541,843,120.17** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,006,357,603.70** | **692,612,919.59** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **618,670,921.40** | **132,720,334.94** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 618,670,921.40 | 132,720,334.94 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 14,262,373.94 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | | 834,370.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | | 13,428,003.94 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 520,670,921.40 | 98,002,622.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | 98,000,000.00 | 20,455,339.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **387,686,682.30** | **559,892,584.65** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 39,870,382.30 | 39,619,484.65 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 24,206,705.00 | 23,790,906.65 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,663,677.30 | 15,828,578.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 347,816,300.00 | 520,273,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 347,816,300.00 | 520,273,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **611,699,173.20** | **791,754,472.23** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **611,699,173.20** | **771,754,472.23** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 563,009,122.95 | 698,763,356.24 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 203,097,761.10 | 281,418,924.00 |
| 210101 | Үндсэн цалин | 155,865,536.00 | 206,095,029.00 |
| 210102 | Нэмэгдэл | 38,627,124.00 | 56,147,040.00 |
| 210104 | Урамшуулал | 8,605,101.10 | 19,176,855.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 25,800,356.00 | 36,115,161.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,724,014.26 | 24,621,859.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,085,218.67 | 2,896,689.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,627,788.95 | 2,295,350.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 383,064.08 | 562,864.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,980,270.04 | 5,738,398.54 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 13,941,906.35 | 14,001,467.94 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,286,998.35 | 11,191,967.94 |
| 210302 | Түлш, халаалт | 5,204,908.00 | 2,809,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 450,000.00 | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 37,322,978.00 | 56,638,930.22 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,621,240.00 | 3,790,160.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 24,519,638.00 | 46,118,274.40 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,944,500.00 | 2,296,580.82 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,190,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,047,600.00 | 4,433,915.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,738,400.00 | 300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,738,400.00 | 300,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,370,000.00 | 14,224,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,370,000.00 | 14,224,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 19,361,582.00 | 30,633,751.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,972,370.00 | 29,218,427.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 621,800.00 | 393,850.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 338,987.00 | 426,492.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 360,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 78,425.00 | 124,982.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 250,376,139.50 | 265,431,121.18 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,715,640.00 | 17,619,533.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 150,000.00 | 1,600,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 228,510,499.50 | 246,211,588.18 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 48,690,050.25 | 72,991,115.99 |

| | | | |
|---|---|---|---|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 35,832,075.50 | 18,083,952.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 2,000,000.00 | 8,684,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,969,070.00 | 7,150,686.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп | 25,563,005.50 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 2,248,766.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 12,857,974.75 | 54,907,163.99 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,857,974.75 | 54,907,163.99 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | **20,000,000.00** |
| 223 | БУСАД ХӨРӨНГӨ | | 20,000,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 20,000,000.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **394,658,430.50** | **(99,141,552.64)** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)** | **60,000.00** | **576,000.00** |
| **14** | **ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО** | **60,000.00** | **576,000.00** |
| 140 | Төсөвт байгууллагын орлого | 60,000.00 | 576,000.00 |
| 140020 | Дансны орлого | 60,000.00 | 576,000.00 |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **16,378,602.22** | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 16,378,602.22 | |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 16,378,602.22 | |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | **378,339,828.28** | **(98,565,552.64)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **387,686,682.30** | **574,154,958.59** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | | **14,262,373.94** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | | 14,262,373.94 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | | 14,262,373.94 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | | 834,370.00 |
| 1200047 | Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө | | 13,428,003.94 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **387,686,682.30** | **559,892,584.65** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 39,870,382.30 | 39,619,484.65 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 24,206,705.00 | 23,790,906.65 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,663,677.30 | 15,828,578.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 347,816,300.00 | 520,273,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 347,816,300.00 | 520,273,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **383,686,682.30** | **529,670,397.67** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **383,686,682.30** | **529,670,397.67** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 334,996,632.05 | 458,148,924.66 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 203,097,761.10 | 281,418,924.00 |
| 210101 | Үндсэн цалин | 155,865,536.00 | 206,095,029.00 |
| 210102 | Нэмэгдэл | 38,627,124.00 | 56,147,040.00 |
| 210104 | Урамшуулал | 8,605,101.10 | 19,176,855.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 25,800,356.00 | 36,115,161.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,724,011.26 | 24,621,859.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,085,217.67 | 2,896,689.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,627,787.95 | 2,295,350.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 383,066.08 | 562,864.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,980,273.04 | 5,738,398.54 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 19,278,034.95 | 19,415,435.94 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,286,998.35 | 11,191,967.94 |
| 210302 | Түлш, халаалт | 10,541,036.60 | 8,223,468.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 450,000.00 | |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 25,997,588.00 | 45,171,538.82 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,788,840.00 | 4,128,660.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,077,648.00 | 31,599,383.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,944,500.00 | 2,296,580.82 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,190,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,996,600.00 | 7,146,915.00 |
| 2105 | Нормативт зардал | 600,000.00 | 600,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 600,000.00 | 600,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 7,654,400.00 | 6,405,850.00 |
| 210604 | Урсгал засвар | 7,654,400.00 | 6,405,850.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 10,370,000.00 | 14,134,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 10,370,000.00 | 14,134,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 19,202,882.00 | 29,932,451.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 17,972,370.00 | 28,358,427.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 463,100.00 | 552,550.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 338,987.00 | 426,492.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 110,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 360,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 78,425.00 | 124,982.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,995,610.00 | 24,955,563.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,845,610.00 | 23,355,563.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 150,000.00 | 1,600,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 48,690,050.25 | 71,521,473.01 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 35,832,075.50 | 18,133,266.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 2,000,000.00 | 8,684,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,144,300.00 | 7,200,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп | 25,387,775.50 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 2,248,766.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 12,857,974.75 | 53,388,207.01 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,857,974.75 | 53,388,207.01 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)** | **4,000,000.00** | **44,484,560.92** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | | **576,000.00** |
| **14** | **ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО** | | **576,000.00** |
| 140 | Төсөвт байгууллагын орлого | | 576,000.00 |
| 140020 | Дансны орлого | | 576,000.00 |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **4,000,000.00** | **32,999,600.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,000,000.00** | **32,999,600.00** |
| 223 | БУСАД ХӨРӨНГӨ | | 20,000,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 20,000,000.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 4,000,000.00 | 12,999,600.00 |
| 2251 | Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн | 4,000,000.00 | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,000,000.00 | 12,999,600.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)** | **(4,000,000.00)** | **(32,423,600.00)** |
| **9** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | | |
| **10** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)** | | |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)** | | **12,060,960.92** |
| **14** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **15** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **12,060,960.92** |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн хөрөнгө | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|

| | | оруулсан капитал | | | |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **448,675,224.79** | **202,615,341.99** | **607,421,487.45** | **1,258,712,054.23** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 2,374,670.30 | 2,374,670.30 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 448,675,224.79 | 202,615,341.99 | 609,796,157.75 | 1,261,086,724.53 |
| 4 | Тайлант үеийн үр дүн | | | 378,339,828.28 | 378,339,828.28 |
| 5 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | | |
| **6** | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **448,675,224.79** | **202,615,341.99** | **988,135,986.03** | **1,639,426,552.81** |
| 7 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 8 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 448,675,224.79 | 202,615,341.99 | 988,135,986.03 | 1,639,426,552.81 |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | | | **(98,565,552.64)** | **(98,565,552.64)** |
| **10** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **448,675,224.79** | **202,615,341.99** | **889,570,433.39** | **1,540,861,000.17** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **11000** | **Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | | |
| **11100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | |
| **11200** | **Кассын оны эхний үлдэгдэл** | | |
| **12** | **Татварын бус орлого** | **521,273,100.00** | **469,566,792.99** |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 1,000,000.00 | 834,370.00 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 520,273,100.00 | 468,732,422.99 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **521,273,100.00** | **469,566,792.99** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **499,584,100.00** | **447,916,792.99** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **481,220,400.00** | **429,783,526.99** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **283,941,300.00** | **281,418,924.00** |
| 210101 | Үндсэн цалин | 207,357,200.00 | 206,095,029.00 |
| 210102 | Нэмэгдэл | 60,676,900.00 | 56,147,040.00 |
| 210104 | Урамшуулал | 15,907,200.00 | 19,176,855.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **42,798,800.00** | **36,115,161.90** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,561,100.00 | 24,621,859.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,559,300.00 | 2,896,689.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,847,600.00 | 2,295,350.44 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 711,900.00 | 562,864.68 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,118,900.00 | 5,738,398.54 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **23,386,000.00** | **13,634,468.27** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,500,000.00 | 5,786,000.27 |
| 210302 | Түлш, халаалт | 16,386,000.00 | 7,848,468.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 500,000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **53,030,800.00** | **40,835,315.82** |
| 210401 | Бичиг хэрэг | 5,480,000.00 | 4,128,660.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,308,200.00 | 31,307,560.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,830,000.00 | 2,046,580.82 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,000,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,412,600.00 | 3,352,515.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **600,000.00** | **600,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 600,000.00 | 600,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **28,552,800.00** | **17,755,450.00** |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 16,000,000.00 | 11,349,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 12,552,800.00 | 6,405,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **14,223,200.00** | **13,414,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 14,223,200.00 | 13,414,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж** | **8,575,800.00** | **7,449,024.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,035,000.00 | 5,875,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 684,000.00 | 552,550.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 736,800.00 | 426,492.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 148,000.00 | 110,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 600,000.00 | 360,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 372,000.00 | 124,982.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **26,111,700.00** | **18,561,183.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,400,400.00 | 16,961,183.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,711,300.00 | 1,600,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **18,363,700.00** | **18,133,266.00** |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | 8,684,500.00 | 8,684,500.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 7,200,000.00 | 7,200,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,479,200.00 | 2,248,766.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **21,689,000.00** | **21,650,000.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 21,689,000.00 | 21,650,000.00 |
| **26** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | | |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| **12000** | **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **12100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | |
| **12200** | **Кассын дансны эцсийн үлдэгдэл** | | |
| **12200** | **Тусламжийн орлого** | **520,273,100.00** | **468,732,422.99** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)** | **40,144,484.65** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **40,144,484.65** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **36,777,997.67** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **5,780,967.67** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,405,967.67 |
| 210302 | Түлш, халаалт | 375,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **4,336,223.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 291,823.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 250,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,794,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **720,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 720,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **22,483,427.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 22,483,427.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,457,380.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,457,380.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,366,486.98** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **3,366,486.98** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,366,486.98 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)** | **40,144,484.65** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **39,619,484.65** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **39,619,484.65** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 23,790,906.65 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 15,828,578.00 |
| **14** | **ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО** | **525,000.00** |
| **140** | **Төсөвт байгууллагын орлого** | **525,000.00** |
| 140020 | Дансны орлого | 525,000.00 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **0.00** |
| **11000** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **12000** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 105,996.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 83,321.4 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 22,675.0 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах хугацаатай албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй 1 зөвлөмж тус тус хүргүүллээ.

***Залруулсан алдаа:***

Аудитаар нийт 83,321.4 мянган төгрөгийн 4 алдаа[1] илрүүлж аудитын явцад бүрэн залруулсан. Үүнд:

- Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 6,011.5 мянган төгрөгийн нэмэлт орлогыг дутуу тайлагнасан.
- Ахмадын сангаас шилжиж ирсэн 13,428.0 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн.
- Мөнгөн гүйлгээний тайланд 12,341.3 мянган төгрөгийн биет бус хөрөнгийн зардлыг дутуу тайлагнасан.
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг дансны 51,540.7 мянган төгрөгийг цэвэрлэх бичилт хийгээгүй.

***Залруулагдаагүй алдаа:***

Аудитаар нийт 22,675.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрч, зөрчил арилгах хугацаатай албан шаардлага хүргүүллээ.

### 3.1 Албан шаардлага

- Ажил хавсран гүйцэтгэж байгаа албан хаагчид 614.4 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2–т /*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*/, 16.5.5-д /*батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*/ заасныг;
- Зарцуулсан шатахууны тооцоог бодож баталгаажуулаагүй, 22,060.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд шууд зардлаар тайлагнасан. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2.4-т /*Мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал болон жижиглэн худалдаалах газар /дэлгүүр, цайны газар, ресторан, бар, зочид буудал гэх мэт/-т байгаа бараа, сав, боодлыг сар бүр /сар бүрийн 1-нээр/*/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.4-т /*Нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах*/ заасныг;
- Бараа материалын тайлан гаргаагүй, тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулаагүй, агуулахын бүртгэл хөтлөөгүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4-т /*аж ахуйн нэгж байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна*/, Эд хариуцагчийн эрх үүргийн дүрмийн 14-т /*хадгалж байгаа зүйлийг нэр төрөл, үнэ зэрэг дугаараар нь ангилан төрөлжүүлж хураан агуулахын үлдэгдлийн бүртгэлийг зохих маягт, зааврын дагуу тогтмол хөтөлж байна*/, 17-д /*өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна*/ заасныг;
- Эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллого хийж, хөрөнгийн үлдэгдлийн тооцоог бодож актаар баталгаажуулаагүй. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д /*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*/, 20.2.6-д /*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*/ заасныг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь: Завсарын аудитаар зөрчлийг таслан зогсоох, албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан байна.*

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой

*Илрүүлэлт:*

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих нийт 157 мэдээллээс 9 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн, хуулийн хэрэгжилт 90.9 хувьтай байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-т "*Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална*", 4.1.1-т "*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*", 4.1.2-т "*мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх*", 4.1.3-т "*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*" заасныг мөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Шилэн дансны тухай хууль, шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга нийтлэг стандарт тогтоосон журмын хэрэгжилтэд хяналт тавих, мэдээллийг бүрэн, хугацаанд нь байршуулах, ажил хариуцсан ажилтны ажлын хариуцлагыг сайжруулж, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, хариуг 2024.05.25-ны дотор гаргаж ирүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:** /мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг дутуу тайлагнасан. | 1 | 6,011.5 | | | 1 | 6,011.5 | 1 | 6,011.5 | | |
| Ахмадын сангаас шилжиж ирсэн мөнгөн хөрөнгийг туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн. | 1 | 13,428.0 | | | 1 | 13,428.0 | 1 | 13,428.0 | | |
| Мөнгөн гүйлгээний тайланд биет бус хөрөнгийн зардлыг дутуу тайлагнасан. | 1 | 12,341.3 | | | 1 | 12,341.3 | 1 | 12,341.3 | | |
| Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг дансыг цэвэрлэх бичилт хийгээгүй. | 1 | 51,540.7 | | | 1 | 51,540.7 | 1 | 51,540.7 | | |
| **Дүн** | **4** | **83,321.4** | **-** | **-** | **4** | **83,321.4** | **4** | **83,321.4** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Ажил хавсран гүйцэтгэж байгаа албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан. | 1 | 614.4 | | | 1 | 614.4 | | | | |
| Зарцуулсан шатахууны тооцоог бодож баталгаажуулаагүй, санхүүгийн тайланд шууд зардлаар тайлагнасан. | 1 | 22,060.5 | | | 1 | 22,060.5 | | | | |
| Бараа материалын тайлан гаргаагүй, тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулаагүй, агуулахын бүртгэл хөтлөөгүй. | 1 | - | | | 1 | - | | | | |
| Эхний хагас жилийн эд хөрөнгийн тооллого хийж, хөрөнгийн үлдэгдлийн тооцоог бодож актаар баталгаажуулаагүй. | 1 | - | | | 1 | - | | | | |
| Дүн | 4 | 22,675.0 | - | - | 4 | 22,675.0 | - | - | - | - |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан | 1 | | | | | | 1 | |
| | | | | | | | | |
| Дүн | 1 | | | | | | 1 | |